ГУРАВДУГААР ХЭСЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэр: Малын зөөврийн хашаа нийлүүлэх
Нийлүүлэх тоо хэмжээ: 250 ширхэг
Төсөвт өртөг: 2,700,000,000.00 (хоёр тэрбум долоон зуун сая) төгрөг

№	Барааны техникийн үзүүлэлт	Барааны техникийн тодорхойлолт, стандартын шаардлага
1	Барааны нэр, загвар, зориулалт	Бэлчээрийн малыг шаардлагатай үед хамгаалан хаших зориулалттай, битүү хучлагатай, 800–1,000 толгой малын багтаамжтай, олон зориулалтаар ашиглах боломжтой зөөврийн хашаа
2	Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаяг	Аль ч улсын байж болно. Үйлдвэрлэгчийн нэр, байршлын хаягыг тодорхой бичнэ.
3	Үйлдвэрлэгчийн болон бүтээгдэхүүний танилцуулга	Үйлдвэрлэгчийн болон бүтээгдэхүүний танилцуулга, ашиглалтын зааврыг Монгол хэл дээр бэлтгэсэн байх
4	Ерөнхий шаардлага	● Малын угсардаг битүү хашааны иж бүрдлийн үндсэн хийц материал нь цайрдсан төмөр эсвэл ган хоолойгоор хийгдсэн, зэвэрдэггүй, холбоосууд бат бөх, тээвэрлэлт болон ашиглалтын явцад гэмтэл үүсэхгүй байна. ● Хашааны хэмжээ 22.0 м X 10 м X 3.3 м-ээс ихгүй, нийт жин 1,2 тонноос ихгүй байна. ● Гадна хучлага буюу бүрээсний материал нь PVC брезент эсвэл түүнтэй дүйцэхүйц PVC-ээр бүрсэн полиэстр даавуу, HDPE суурьтай нэхмэл даавуу байх бөгөөд халуун, хүйтэнд хэврэгшихгүй, механик шинж чанараа алдахгүй, ус, салхи нэвтрүүлэхгүй, нарны гэрлийг хагас нэвтрүүлэх боломжтой, UV хамгаалалттай, удаан эдэлгээтэй материал байна. ● Малын хашаа нь бага оврын ачааны машинд багтахуйц, газар дээр суурь цутгалгүйгээр шууд угсарч ашиглах боломжтой, олон дахин угсарч задлахад хийцийн бат бөх чанар алдагдахгүй байна.
5	Байгууламжид тавигдах шаардлага	● Хашааны нийт урт 20-22 м, өргөн нь 8-10 м, 1-2 хаалгатай, дээврийн хамгийн өндөр хэсэгтээ 3.1-3.3 м, хамгийн нам хэсэгтээ 1.6-1.8 м хэмжээтэй, битүү хучлагатай байна. ● Дээвэр хэсэг нь нум хэлбэртэй, салхи, шуурга болон цасны ачаалал даах чадвартай.

		● Дээвэр нь үндсэн хашаатайгаа салдаг нугас, эсвэл холбоос төмрөөр холбогдсон, ердийн үед дээврийн нум, хучлагыг хурааж хашааг олон төрлөөр ашиглах боломжтой байна. ● Хашаа бүр нь 6-8 хэвтээ хөндлөвчтэй байх ба хаалганы доод талын хөндлөвчүүдийн хоорондын зай илүү ойр байна. ● Хашааг 1.2-1.8 мм зузаантай, зэвэрдэггүй цайрдсан ган төмөр буюу түүнтэй дүйцэх бат бөх металлаар хийсэн байна. ● Хашааны бэлдэц хоорондын бэхэлгээ, түгжээ төмөр нь бат бөх, ашиглахад хялбар, малын биед гэмтэл учруулахгүй буюу тавлаг байдлыг хангасан байна. ● Иж бүрдэл бүрт 1-2 ширхэг хаалга байх ба хаалгыг үндсэн хашаанд залгаж ашиглах боломжтой, хурдан хугацаанд нээх, хаах, түгжих ажлыг хялбаршуулсан бүтэц, ажиллагаатай байна. ● Хаалга, түгжээ нь найдвартай, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн байна.
6	Угсралт, ашиглалтын шаардлага	● Угсралтыг тусгай механизмгүйгээр хүний хүчээр гүйцэтгэх боломжтой байна. ● Угсрах схем, заавар багцад дагалдаж нийлүүлэгдсэн байна. ● Ашиглалтын явцад байгууламжийн агааржуулалтыг нэмэх, тохируулах боломжтой байна. ● Газар бэхлэх анкер, шонгоор суурилуулах боломжтой
7	Чанар, аюулгүй байдлын шаардлага	● Хурц ирмэг, мал болон хүнд аюул учруулах ил гарсан хэсэггүй байна.
8	Бусад шаардлага	● Техникийн гэрчилгээтэй байна. ● Угсралт, ашиглалтын заавартай байна.

Жич: Нийлүүлэгчийн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох зорилгоор үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан каталог, танилцуулга, зураг, туршилт шинжилгээ, судалгааны дүн гэх мэт материалыг хавсаргаж ирүүлсэн байна.